

бүс нутгийг нөхөн сэргээх ажлуудын хоорондын холбоо уялдааны талаархи мэдлэг нэмэгдэж, улмаар шийдвэр гаргахад нөлөөлөх чухал хэрэгсэл бий болсон байна

Гарах үр дүн 3.5: бодлого боловсруулагч, эцсийн хэрэглэгч нарыг дэмжих зорилгоор дэлхий нийт, бүсийн болон салбар бүс, үндэсний түвшний мэдлэг солилцох тогтолцоо, ялангуяа уламжлалт мэдлэгээ хуваалцах, тэр дундаа шилдэг туршлага, амжилтуудаа илрүүлэн, солилцох үйл явц идэвхижсэн байна

Гарах үр дүн 3.6: шинжлэх ухаан технологийн сүлжээ болон цөлжилт/газрын доройтол, ган хуурайшилтын чиглэлийн байгууллага институциуд Конвенцийг хэрэгжүүлэхэд дэмжин оролцоно

#### 4. Чадавхи бэхжүүлэх

*Цөлжилт/газрын доройтолын үйл явцыг сааруулах, тэдгээрээс урьдчилан сэргийлж, ган хуурайшилтийн үр нөлөөг хөнгөрүүлэх чиглэлийн чадавхийг бэхжүүлэх шаардлага, хэрэгцээг илрүүлж, шийдвэрлэх*

Гарах үр дүн 4.1: үндэсний чадавхийн үнэлгээгээ хийсэн орнууд хувь хүн, байгууллага, тогтолцооны түвшинд шаардлагатай чадавхийг бий болгохын тулд тодорхой үр дүнд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлж, үндэсний болон орон нутгийнхаа түвшинд цөлжилт/газрын доройтол, ган хуурайшилттай тэмцсэн байна

Гарах үр дүн 4.2: чадавхийн хэрэгцээ шаардлагын үнэлгээгээ урд өмнө нь хийгээгүй орнууд үндэсний болон орон нутгийн түвшинд цөлжилт/газрын доройтол, ган хуурайшилттай тэмцэх чадавхи боломжоо илрүүлэх зорилгоор үнэлгээ хийх холбогдох үйл явцад оролцсон байна

#### 5. Санхүүжилт ба технологи шилжүүлэлт

*Үндэсний болон хоёр ба олон талт санхүү, технологийн нөөц боломжийн зорилго, тэдгээр хоорондын зохицуулалтыг идэвхижүүлэн нэмэгдүүлж, ажлын нөлөө, үр ашгийг дээшлүүлэх*

Гарах үр дүн 5.1: өртсөн гишүүн орнууд үндэсний болон хоёр ба олон талт нөөц боломжоо нэгтгэх хөрөнгө оруулалтын нэгдсэн тогтолцоо бий болгож, хэрэгжүүлж буй ажил үйл ажиллагааны нөлөө, үр ашгийг дээшлүүлсэн байна

Гарах үр дүн 5.2: хөгжингүй гишүүн орнууд цөлжилт/газрын доройтол, ган хуурайшилтийн үйл явцыг сааруулж, урьдчилан сэргийлж, ган хуурайшилтийн үр нөлөөг хөнгөрүүлэхэд чиглэсэн орон нутгийн санал санаачлагыг дэмжихийн тулд томоохон, хүрэлцэхүйц хэмжээний, цагаа олсон, урьдчилж таамагласан санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна

Гарах үр дүн 5.3: гишүүн орнууд GEF буюу Даян дэлхийн байгаль орчны сан зэрэг олон улсын бусад сан, санхүүгийн байгууллагын удирдлагуудад Конвенци дах газрын тогтвортой менежментийн хөтөлбөрийг ухуулан сурталчилах замаар санхүүжилт татах хүчин чармайлтаа нэмэгдүүлсэн байна

Гарах үр дүн 5.4: цөлжилт/газрын доройтолтой тэмцэж, ган хуурайшилтийн үр нөлөөг бууруулах зорилгод хүрэхийн тулд хувийн

салбар, худалдаа зах зээл, төрөл бүрийн сан, зээлийн боломжууд зэрэг санхүү, санхүүжилтийн шинэлэг тогтолцоо илрүүлэхээс гадна уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох/сааруулах, биологийн төрөл зүйлийг хамгаалах, тогтвортой ашиглах, ядуурал, өлсгөлөнг бууруулахад чиглэсэн санхүүгийн механизмуудыг хамруулсан байна

Гарах үр дүн 5.5: өртсөн гишүүн орнууд өмнөд-өмнөдийн болон хойд өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд боломжийн хэмжээний санхүүжилт, эдийн засаг, бодлогын урамшуулал, техникийн дэмжлэг авсанаар технологиуд хэрэгжүүлэх боломжтой болсон байна

НҮБ-ЫН ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ КОНВЕНЦИ

**НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх 10 жилийн стратеги төлөвлөгөө ба цар хүрээ**

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхий нийтийн түншлэлийг бий болгох, цөлжилт, газрын доройтолын үйл явцыг сааруулах, урьдчилан сэргийлэх, ядуурлыг бууруулж, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтыг бий болгох зорилгоор цөлжилтөнд өртсөн хуурай газар нутагт ган хуурайшилтийн хор уршгийг хөнгөрүүлэх



НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенци

Hermann-Ehlers-Str. 10  
53173 Bonn, Germany  
Утас.: (49-228) 815 2800  
Факс: (49-228) 815 2998/99  
И-мэйл: [secretariat@unccd.int](mailto:secretariat@unccd.int)  
Вэб хуудас: [www.unccd.int](http://www.unccd.int)

Рио де Жанейро хотноо болсон дээд хэмжээний уулзалтын үр дүн болох НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенци нь (Конвенци) нь эмзэг бүлгийн ард иргэд гол төлөв оршин суудаг дорой эко систем бүхий хуурай бүс нутгийн газрын доройтолын асуудалд анхаарал татсан цорын ганц хэрэгсэл юм.

Конвенци нь батлагдсанаасаа хойш 10 жилийн дараа гишүүн орнуудын үр ашгийг хүртсээр ирсэн ба түүнийг дэлхий нийтэд тогтвортой хөгжлийг бий болгож, ядуурлыг бууруулахад урт хугацааны хувь нэмэр оруулж чадахуйц хэрэгсэл хэмээн жил ирэх тусам хүлээн зөвшөөрч байна.

Конвенцийн хэрэгжилт 2 дахь үе шатандаа шилжин орж байгаатай холбогдуулан 2007 оны 09 сард Испани улсын Мадрид хотноо болсон COP 8 уулзалтын үеэр 192 гишүүн орнууд 2008–2018 онд Конвенцийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 10 жилийн стратеги төлөвлөгөө, үйл ажиллагааны цар хүрээг (Стратеги гэнэ) санал нэгтгэжээ батласан юм. Энэхүү Стратеги нь Конвенцийн зарим нэг гол асуудлыг шийдвэрлэх, түүний хүчин чармайлтыг бүртгэн баримтжуулах, шинэ бодлого боловсруулах, байгаль орчинд оруулж буй хөрөнгө оруулалтыг татах, Конвенцийн бүх гишүүн орнуудад хамтын ажиллагааны шинэ суурь бий болгоход цорын боломж олгож байгаагаараа онцлогтой.

Стратеги нь 10 жилийн туршид хүрэх стратегийн зорилтууд болон богино, дунд хугацааны үр дүнд чиглэсэн ажлуудыг зохицуулах үүрэг бүхий үйл ажиллагааны зорилтуудаас бүрдэнэ.

## СТРАТЕГИЙН ЗОРИЛТУУД БА ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ НӨЛӨӨ:

### 1. Өртсөн иргэдийн амьжиргааны нөхцөлийг сайжруулах:

Хүлээгдэж буй нөлөө 1.1: цөлжилт/газрын доройтол, ган хуурайшилтанд өртсөн бүс нутгийн иргэдийн амьжиргааны түвшин сайжирч, орлогын эх үүсвэр нь төрөлжиж, газрын тогтвортой менежментийг хэрэгжүүснээр орлого нь нэмэгдэнэ

Хүлээгдэж буй нөлөө 1.2: өртсөн иргэдийн нийгэм–эдийн засгийн түвшин сайжирч, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ган, хуурайшилтанд эмзэг байх байдал буурна

### 2. Өртсөн экосистемийн нөхцөл байдлыг сайжруулах

Хүлээгдэж буй нөлөө 2.1: өртсөн бүс нутгийн газрын үйлдвэрлэл, бусад экосистемийн бүрэлдэхүүн, үйлчилгээ тогтмолжин нэмэгдэж, улмаар амьжиргааны нөхцөл сайжирхад хувь нэмэр оруулна

Хүлээгдэж буй нөлөө 2.2: өртсөн экосистемийн уур амьсгалын өөрчлөлт, ган хуурайшилтанд эмзэг байх байдал буурна

### 3. Конвенцийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх замаар дэлхийн нийтийн хэмжээнд ашиг тус хүргэх/бий болгох

Хүлээгдэж буй нөлөө 3.1: газрын тогтвортой менежментийг нэвтрүүлж, цөлжилт/газрын доройтолтой тэмцэх нь биологийн төрөл зүйлийн тогтвортой ашиглалт, хамгаалалт болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг намжаахад/саарулахад хувь нэмэрээ оруулна

### 4. Нөөц, боломжоо дайчлан үндэсний болон олон улсын оролцогсдын хоорондын түншлэл хамтын ажиллагааг бий болгох замаар Конвенцийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх

Хүлээгдэж буй үр нөлөө 4.1: өртсөн хөгжиж буй гишүүн орнууд нэмэгдсэн санхүү, техник технологийн нөөц боломжийн нөөц боломжийг ашиглах боломжтой болж, Төв болон Зүүн Европын орнууд шаардлагатай бүс нутагтаа Конвенцийг хэрэгжүүлэх болно

Хүлээгдэж буй үр дүн 4.2: Конвенцийг бүх түвшинд хэрэгжүүлэх бодлогын орчин бүрэлдсэн байна



## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТУУД БА ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ НӨЛӨӨ:

### 1. Сурталчилгаа, боловсрол, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх

Цөлжилт/газрын доройтол болон ган хуурайшилтын асуудалд бодитойгоор анхааралаа хандуулдаг болоход нь үндэсний болон олон улсын холбогдох байгууллага, орон нутгийн оролцогсод идэвхитэй нөлөөлөх

Гарах үр дүн 1.1: цөлжилт/газрын доройтол, ган хуурайшилтын асуудлууд ба эдгээрийн уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, биологийн төрөл зүйл хамгалаах асуудлуудтай холбогдох байдлыг олон улс, үндэсний болон орон нутгийн түвшний байгууллагуудад мэдээлэл хариалцаагаар дамжуулан идэвхитэй таниулан сурталчилна

Гарах үр дүн 1.2: хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний худалдаа, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, биологийн төрөл зүйл хамгаалах ба тогтвортой ашиглах, хөдөөгийн хөгжил, тогтвортой хөгжил болон ядуурлыг бууруулах асуудлаархи олон улсын цуглаан, форумын үеэр цөлжилт/газрын доройтол, ган хуурайшилтын асуудлыг хөндөн ярилцах

Гарах үр дүн 1.3: Өмнөд Дорнодын иргэний нийгэм болон шинжлэх ухааны байгууллагууд гол оролцогчид гэсэн утгаараа Конвенцийн хэрэгжилтийн үйл явцад оролцох байдал нь идэвхижиж, сурталчилгаа, мэдлэг мэдээлэл дээшлүүлэх, боловсрол нэмэгдүүлэх санал санаачлагаараа дамжуулан цөлжилт/газрын доройтол, ган хуурайшилтийн асуудлыг гаргаж ирэх/хөндөх

### 2. Бодлогын цар хүрээ

Цөлжилт/газрын доройтолтой тэмцэх, ган хуурайшилтын үр нөлөөг сааруулах шийдвэрүүдийг нэвтрүүлэхэд чиглэсэн орчин бий болгоход дэмжлэг үзүүлэх

Гарах үр дүн 2.1: цөлжилт/газрын доройтолын асуудлыг шийдвэрлэх бодлого, бүтэц, санхүү, нийгэм эдийн засгийн хөшүүрэг болон газрын тогтвортой менежментийг нэвтрүүлэхэд тулгарч буй саад бэрхшээлд үнэлгээ өгч, эдгээр бэрхшээлийг даван туулахад тохиромжтой арга хэмжээг санал болгоно

Гарах үр дүн 2.2: өртсөн гишүүн орнууд тус бүр нь үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрөө стратегийн баримт бичиг болгон шинэчлэн боловсруулж, үүнд биофизик болон нийгэм эдийн засгийн суурь мэдээ мэдээллийг түлхүү тусган оруулж, тэдгээрийг хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөнд оруулна

Гарах үр дүн 2.3: өртсөн гишүүн орнууд үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр болон газрын тогтвортой менежмент, доройтолын асуудлаа хөгжлийн төлөвлөгөө, холбогдох салбарын болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, бодлого болон нэгтгэнэ

Гарах үр дүн 2.4: Хөгжингүй гишүүн орнууд Конвенцийн зорилго, газрын тогтвортой менежментэд чиглэсэн санал санаачлагаа улс орныхоо хөгжлийн хамтын ажиллагааны төсөл/хөтөлбөрүүдэд чиглүүлж, үндэсний хэмжээний бүсийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үзүүлж буй дэмжлэгтэй уялдуулна

Гарах үр дүн 2.5: цөлжилт/газрын доройтолын эсрэг үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх, биологийн төрөл зүйл хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг сааруулах, түүнд дасан зохицох ажлыг хамтын хүчээр нэмэгдүүлэх арга хэмжээг нэвтрүүлэн бэхжүүлж, улмаар оролцоо, хувь нэмэрийн үр нөлөөг дээшлүүлэх



### 3. Шинжлэх ухаан, технологи ба мэдлэг

Цөлжилт/газрын доройтол, ган хуурайшилтийн нөлөөг бууруулахад чиглэсэн шинжлэх ухаан, технологийн мэдлэгээр дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэгч нь болно

Гарах үр дүн 3.1: өртсөн орнуудын био физик болон нийгэм эдсийн засгийн чиг хандлагад үндэсний хэмжээний мониторинг, эмзэг байдлын үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлнэ

Гарах үр дүн 3.2: биофизик, нийгэм эдийн засгийн чиг хандлагын талаархи мэдээ мэдээлэлд тулгуурласан суурь мэдээлэл бий болгож, шинжлэх ухааны холбогдох арга барилуудтай үе шаттайгаар уялдуулах

Гарах үр дүн 3.3: өртсөн орнуудын биофизик, нийгэм эдийн засгийн хүчин зүйлс болон тэдгээрийн хоорондын холбооны талаархи мэдлэг нэмэгдэж улмаар шийдвэр гаргах үйл явц сайжирна

Гарах үр дүн 3.4: уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, ган хуурайшилтийн үр нөлөөг бууруулах, өртсөн газруудын доройтсон